



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2021 оны 08 сарын 30 өдөр

Дугаар А/405

Арвайхээр

Аттестатчилал зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3.а, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2020 оны 08 дугаар сарын 19-ний өдрийн "Норматив тогтоох тухай" А/272 дугаар тушаалыг үндэслэн, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд, Өвөрхангай аймгийн Засаг дарга нарын 2021 онд хамтран ажиллах гэрээний 39 дэх заалтыг хэрэгжүүлэх зорилгоор ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн хэмжээнд архи, согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх цэгүүдийг аттестатчилалд хамруулах, хууль тогтоомжийн хэрэгжилтэд үнэлгээ хийж, дүгнэлт гаргах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, удирдамжийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Аттестатчиллыг 2021 оны 09 дүгээр сард багтаан зохион байгуулж, дүн мэдээг аймгийн Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулахыг ажлын хэсгийн ахлагч аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга (А.Отгонцэцэг)-т даалгасугай.

3.Коронавируст халдвар (ковид-19)-ын нөхцөл байдалтай уялдуулан сумдын нутаг дэвсгэрт ажиллах ажлын хэсгийн хяналт шалгалтад дэмжлэг үзүүлж, хамтран ажиллахыг сумдын Засаг дарга, аймгийн Засаг даргын дэргэдэх Эрүүл мэндийн газар (Д.Шивааннүрдэв), Мэргэжлийн хяналтын газар (С.Дуламсүрэн), аймгийн Цагдаагийн газар (цагдаагийн хурандаа Б.Мөнх-Эрдэнэ)-т тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

011100863

D:My Doc. Zahiramj. Zasag darga



Аймгийн Засаг даргын 2021 оны
дугаар сарын-ны өдрийн дугаар
захирамжийн нэгдүгээр хавсралт

АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

- Ажлын хэсгийн ахлагч: А.Отгонцэцэг (аймгийн Засаг даргын Тамгын газрын
Хууль, эрх зүйн хэлтсийн дарга)
Нарийн бичгийн дарга: Б.Анхбилэг (аймгийн Засаг даргын Тамгын газрын
Хууль, эрх зүйн хэлтсийн мэргэжилтэн)
Гишүүдэд: Ч.Гүнсэнхорол (аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө
оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга)
Б.Мөнх- Эрдэнэ (аймгийн Цагдаагийн газрын дарга)
С.Дуламсүрэн (аймгийн Засаг даргын дэргэдэх Мэргэжлийн хяналтын
газрын дарга)
Г.Мөнхтөр (аймгийн Засаг даргын дэргэдэх Стандартчилал, хэмжил
зүйн хэлтсийн дарга)
С.Цэдэнбалжир (аймгийн Засаг даргын дэргэдэх Хүнс, хөдөө аж ахуйн
газрын дарга)
Н.Эрдэнэсүвд (аймгийн Засаг даргын дэргэдэх Татварын хэлтсийн
дарга)
Т.Цэдэнсодном (аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг
зохицуулах зөвлөлийн нарийн бичгийн дарга)
Сумдын Засаг дарга

-оОо-

Аймгийн Засаг даргын 2021 оны 08 дугаар сарын 30-ны өдрийн 405 дугаар захирамжийн хоёрдугаар хавсралт

**АЙМГИЙН ХЭМЖЭЭНД ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛЖ БАЙГАА
СОГТУУРУУЛАХ УНДАА ХУДАЛДАХ, ТҮҮГЭЭР ҮЙЛЧЛЭХ ТУСГАЙ
ЗӨВШӨӨРӨЛТЭЙ ЦЭГҮҮДЭД ҮНЭЛГЭЭ ХИЙХ, ДҮГНЭЛТ
ГАРГАХ АЖЛЫН УДИРДАМЖ**

2021.08.30

Арвайхээр

Зорилго: Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль, Архидан согтуурахтай тэмцэх тухай хууль, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2020 оны 08 дугаар сарын 19-ний өдрийн “Норматив тогтоох тухай” А/272 дугаар тушаал, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 5 дугаар сарын 06-ны өдрийн 04/02 дугаар тогтоолоор батлагдсан “Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл олгох, хүчингүй болгох, хяналт тавих журам”-ын хэрэгжилтийг хангах зорилгоор аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй иргэн, аж ахуйн нэгжийн үйлчилгээний цэгт аттестатчилал хийж, үр дүнг үнэлэхэд оршино.

Үнэлгээ хийх албан хаагч нь эрх, үүргийхээ хүрээнд дараах зарчмыг баримтлан ажиллана. Үүнд:

1. Хууль дээдлэх, шударга, хараат бус байх;
2. Үнэлгээний үйл ажиллагаа нээлттэй, ил тод байх;
3. Үнэлгээ нь эрх бүхий байгууллагуудын хууль, журмаар тогтоосон шалгуур үзүүлэлт, тоо баримт, судалгаа, шинжилгээнд үндэслэсэн байх;
4. Үнэлгээний үнэн зөв байдлыг холбогдох байгууллага, албан тушаалтан хариуцах;

Хамрах хүрээ: Аймгийн нийт нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй иргэн аж, ахуй нэгжийн согтууруулах ундаа худалдах, үйлчлэх цэг

Хугацаа: 2021 оны 09 дүгээр сарын 01-ний өдрөөс 09 дүгээр сарын 20-ны дотор сумдад очиж үнэлгээ хийнэ.

Сумдад очиж ажиллахад үнэлгээнээс татгалзсан цэгийг үнэлгээнд оруулахгүй бөгөөд тусгай зөвшөөрлийг хүчингүйд тооцох үндэслэл болно.

Гүйцэтгэх үйл ажиллагаа:

- Худалдаа, үйлчилгээний салбарт мөрдөгдөж байгаа Монгол Улсын хууль болон орон нутгийн хэмжээнд нийтээр дагаж мөрдүүлэхээр баталсан захиргааны хэм хэмжээ тогтоосон шийдвэрүүдийн хэрэгжилтийн байдалд дүгнэлт хийнэ.

- Мөн худалдаа, үйлчилгээний салбарт мөрдөгдөж байгаа стандарт тогтоох эрх бүхий төрийн захиргааны төв байгууллагаас баталсан стандартуудын биелэлтийг тусгайлан боловсруулсан хүснэгтийн дагуу шалгаж биелэлтийн хувийг тогтооно.

- Стандартын хэрэгжилтийг 90 хувиас доош гарсан тохиолдолд тухайн аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг зогсоож хугацаатай албан мэдэгдэл өгнө.

- Аттестатчилалд хамрагдсан байгууллага бүрт стандартын хүснэгтийг 2 хувь бөглөнө. Мөн тусгай тэмдэглэл хөтөлж тухайн аж ахуйн нэгжийн албан тушаалтнаар гарын үсэг зуруулж баталгаажуулна.

- Иргэд, төрийн албан хаагч, худалдаа, үйлчилгээ эрхлэгч иргэн, аж ахуйн нэгжид холбогдох хууль тогтоомжоор сургалт, мэдээллийн үйл ажиллагааг тухай бүр зохион байгуулж ажиллана.

- Хойшлуулушгүй тохиолдолд иргэн, аж ахуйн нэгжийн гаргасан зөрчлийг газар дээр нь тухай бүр шийдвэрлэж, хариуцлага тооцно.

Үр дүн: Аттестатчиллыг зохион байгуулснаар хууль тогтоомжийн хэрэгжилт, стандартын шаардлага хангагдана. Худалдаа, үйлчилгээний чанарын түвшин дээшилж үйлчлүүлэгчдийн эрх ашиг хамгаалагдана. Гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажилд ахиц гарна. Нийгэмд сөрөг нөлөө үзүүлэх үйл ажиллагаа явуулж байгаа болон стандартын шаардлага хангаагүй байгууллагуудын үйл ажиллагааг зогсооно.

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ХЭЛТЭС